



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2025/081/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,  
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл  
Утас: 70422954 Цахим хаяг: [aigul@audit.gov.mn](mailto:aigul@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат  
Утас: 70007275 Цахим хаяг: [lightanddelightaudit@gmail.com](mailto:lightanddelightaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Г. АМАНТАЙ ТАНАА**

2025.02.24 № 153  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2024 онд 4,554.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 4,377.0 сая төгрөг зарцуулж, 96.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

## **Бусад асуудлын хэсэг**

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго, 5 зорилтын хүрээнд нийт 89 арга хэмжээ 87.5 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>269,540,218.92</b>	<b>289,783,121.69</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	160,206,761.02	179,257,973.79
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	160,206,761.02	179,257,973.79
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	160,206,761.02	179,257,973.79
31211	Төрийн сангийн харилцах	160,206,761.02	179,257,973.79
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,542,644.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,542,644.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	105,790,813.90	110,525,147.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	105,790,813.90	110,525,147.90
35410	Бичиг хэргийн материал	1,117,348.00	749,082.00
35420	Аж ахуйн материал	5,935,160.00	10,237,760.00
35470	Бусад хангамжийн материал	98,738,305.90	99,538,305.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,924,326,531.46</b>	<b>2,221,950,403.36</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,924,326,531.46	2,221,950,403.36
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,716,082,454.41	2,020,887,374.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,845,948,850.18	1,869,948,850.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(509,674,807.03)	(589,943,563.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,750,000.00	289,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,662,500.00)	(13,345,416.67)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	395,384,438.47	514,989,543.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(247,675,251.09)	(286,589,092.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,929,748.36	197,487,836.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(105,683,208.35)	(123,797,766.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,644,200.00	61,644,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(45,524,666.35)	(52,172,866.31)
39217	Ном	152,645,650.22	152,965,650.22
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	208,244,077.05	201,063,029.25
39301	Програм хангамж	2,173,239.00	2,173,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(821,161.95)	(1,105,809.75)
39303	Бусад биет бус хөрөнгө	206,892,000.00	206,892,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,896,400.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,193,866,750.38</b>	<b>2,511,733,525.05</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>211,888,312.00</b>	<b>220,653,706.10</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	211,888,312.00	220,653,706.10
<b>413</b>	<b>Өглөг</b>	211,888,312.00	220,653,706.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,374,629.98
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	211,888,312.00	216,279,076.12
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,981,978,438.38</b>	<b>2,291,079,818.95</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,981,978,438.38	2,291,079,818.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	933,880,457.00	933,880,457.00
51101	Өмч:- төрийн	933,880,457.00	933,880,457.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(326,698,703.89)	(17,597,323.32)
51210	Өмнөх үеийн үр дүн	(326,698,703.89)	(326,698,703.89)
51220	Тайлант үеийн үр дүн	-	309,101,380.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,374,796,685.27	1,374,796,685.27
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,193,866,750.38</b>	<b>2,511,733,525.05</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,389,992,687.00</b>	<b>4,802,593,593.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,129,887.00</b>	<b>406,500,593.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,129,887.00</b>	<b>406,500,593.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	350,648.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,648.00	-
120009	Бусад орлого	-	1,906,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	5,779,239.00	404,594,193.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,383,862,800.00</b>	<b>4,396,093,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,102,697,500.00</b>	<b>4,029,762,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	4,029,762,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,102,697,500.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>281,165,300.00</b>	<b>366,330,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	281,165,300.00	366,330,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,382,215,567.32</b>	<b>4,493,492,212.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,382,215,567.32</b>	<b>4,493,492,212.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,265,803,158.32</b>	<b>4,343,763,360.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,383,532,508.76</b>	<b>3,253,993,198.50</b>
210101	Үндсэн цалин	1,611,935,837.35	2,132,900,404.90
210102	Нэмэгдэл	664,294,362.89	865,476,347.00
210104	Урамшуулал	107,302,308.52	255,616,446.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>298,176,307.47</b>	<b>409,371,929.98</b>
210201	Тэтгэврийн даатгал	198,566,012.00	280,162,829.98
210202	Тэтгэмжийн даатгал	24,194,300.00	32,302,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,355,500.00	16,151,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,838,700.00	16,151,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	51,221,795.47	64,604,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>363,552,668.40</b>	<b>368,221,564.12</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,784,300.00	14,503,598.00
210302	Түлш, халаалт	340,547,368.40	328,496,966.12
210303	Цэвэр, бохир ус	15,221,000.00	25,221,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,600,000.00</b>	<b>2,086,500.00</b>
210604	Урсгал засвар	1,600,000.00	2,086,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,044,335.22</b>	<b>56,263,810.28</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,044,335.22	56,263,810.28
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>204,897,338.47</b>	<b>253,826,357.41</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,211,400.00	70,335,788.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,197,500.00	27,681,248.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,488,438.47	155,809,321.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>116,412,409.00</b>	<b>149,728,852.14</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>116,412,409.00</b>	<b>149,728,852.14</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	116,412,409.00	149,728,852.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>7,777,119.68</b>	<b>309,101,380.57</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>7,777,119.68</b>	<b>309,101,380.57</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>3,384,213,448.00</u></b>	<b><u>4,397,999,400.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>350,648.00</b>	<b>1,906,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	350,648.00	1,906,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	350,648.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,648.00	00.00
120009	Бусад орлого	00.00	1,906,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,383,862,800.00</b>	<b>4,396,093,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	4,029,762,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	4,029,762,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,102,697,500.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	281,165,300.00	366,330,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	281,165,300.00	366,330,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>3,160,556,300.98</u></b>	<b><u>4,377,041,787.23</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,160,556,300.98</b>	<b>4,377,041,787.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,044,143,891.98</b>	<b>4,228,047,337.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,383,532,508.76	3,230,207,087.64
210101	Үндсэн цалин	1,611,935,837.35	2,056,989,843.81
210102	Нэмэгдэл	664,294,362.89	911,518,319.36
210104	Урамшуулал	107,302,308.52	261,698,924.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	302,428,500.00	403,778,600.00
210201	Тэтгэврийн даатгал	205,651,300.00	274,569,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	24,194,300.00	32,302,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,355,500.00	16,151,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,838,700.00	16,151,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,388,700.00	64,604,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	279,565,300.00	363,830,800.00
210301	Гэрэл, цахилгаан	7,784,300.00	14,503,598.00
210302	Түлш, халаалт	256,560,000.00	324,106,202.00
210303	Цэвэр, бохир ус	15,221,000.00	25,221,000.00
<b>2106</b>	<b>Эд хопшил, урсгал засварын зардал</b>	1,600,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	2,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,044,335.22	63,324,391.59
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,044,335.22	63,324,391.59
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	62,973,248.00	164,406,458.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,562,048.00	131,932,558.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,411,200.00	32,473,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>116,412,409.00</b>	<b>148,994,450.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	116,412,409.00	148,994,450.00

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	116,412,409.00	148,994,450.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>223,657,147.02</u></b>	<b><u>88,095,412.77</u></b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>78,823,000.00</b>	<b>69,044,200.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>78,823,000.00</b>	<b>69,044,200.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	78,823,000.00	69,044,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	78,823,000.00	69,044,200.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-78,823,000.00</u></b>	<b><u>-69,044,200.00</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	144,834,147.02	19,051,212.77
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	15,372,614.00	160,206,761.02
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	160,206,761.02	179,257,973.79

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	933,880,457.00	1,374,796,685.27	(334,475,823.57)	1,974,201,318.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>933,880,457.00</b>	<b>1,374,796,685.27</b>	<b>(334,475,823.57)</b>	<b>1,974,201,318.70</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,777,119.68	7,777,119.68
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>933,880,457.00</b>	<b>1,374,796,685.27</b>	<b>(326,698,703.89)</b>	<b>1,981,978,438.38</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>933,880,457.00</b>	<b>1,374,796,685.27</b>	<b>(326,698,703.89)</b>	<b>1,981,978,438.38</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	309,101,380.57	309,101,380.57
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>933,880,457.00</b>	<b>1,374,796,685.27</b>	<b>(17,597,323.32)</b>	<b>2,291,079,818.95</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/Төгрөгөөр/
					Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,554,643,000.00</b>	<b>4,377,041,787.23</b>	<b>177,601,212.77</b>	<b>96.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,554,643,000.00	4,377,041,787.23	177,601,212.77	96.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,391,422,700.00	4,228,047,337.23	163,375,362.77	96.3
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,325,074,000.00	3,230,207,087.64	94,866,912.36	97.1
210101	Үндсэн цалин	2,253,071,100.00	2,056,989,843.81	196,081,256.19	91.3
210102	Нэмэгдэл	923,672,800.00	911,518,319.36	12,154,480.64	98.7

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	148,330,100.00	261,698,924.47	(113,368,824.47)	176.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	415,633,900.00	403,778,600.00	11,855,300.00	97.1
210201	Тэтгэврийн даатгал	282,631,200.00	274,569,500.00	8,061,700.00	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	33,250,700.00	32,302,300.00	948,400.00	97.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,625,300.00	16,151,100.00	474,200.00	97.1
210204	Ажилгүйдлийн даатгал	16,625,300.00	16,151,100.00	474,200.00	97.1
210205	Эрүүл мэндийн даатгал	66,501,400.00	64,604,600.00	1,896,800.00	97.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	363,830,800.00	363,830,800.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	10,183,800.00	10,183,800.00	-	100.0
210302	Түлш, халаалт	328,426,000.00	328,426,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	25,221,000.00	25,221,000.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хопшил, урсгал засварын зардал</b>	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	80,222,700.00	63,324,391.59	16,898,308.41	78.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,906,400.00	-	1,906,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	78,316,300.00	63,324,391.59	14,991,908.41	80.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	204,161,300.00	164,406,458.00	39,754,842.00	80.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	171,687,400.00	131,932,558.00	39,754,842.00	76.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,473,900.00	32,473,900.00	-	100.0
<b>212</b>	<b>ТАТААС</b>	163,220,300.00	148,994,450.00	14,225,850.00	91.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	163,220,300.00	148,994,450.00	14,225,850.00	91.28
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	163,220,300.00	148,994,450.00	14,225,850.00	91.28
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	163,220,300.00	148,994,450.00	14,225,850.00	91.28
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,554,643,000.00</b>	<b>4,396,093,000.00</b>	<b>158,550,000.00</b>	<b>96.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	4,029,762,200.00	4,029,762,200.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,029,762,200.00	4,029,762,200.00	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	366,330,800.00	366,330,800.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	366,330,800.00	366,330,800.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	158,550,000.00	-	158,550,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,906,400.00	-	1,906,400.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	156,643,600.00	-	156,643,600.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>160,206,761.02</b>	<b>(160,206,761.02)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>179,257,973.79</b>	<b>(179,257,973.79)</b>	<b>-</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	138	138	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	97	97	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	40	40	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь бүрэн дунд боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Эрхэм зорилго нь “Тохилог орчин чанартай сургалт явуулахад оршино”.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль;
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам” батлах тухай
- Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам” батлах тухай
- Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам” батлах тухай
- Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох” тухай
- Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах” тухай
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баян-Өлгий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022, 2023 оны санхүүгийн баримтад шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 23 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг

мөрдөж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 317,866.8 мянган төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	160,206.8	179,258.0	19,051.2
Авлага	3,542.6	-	(3,542.6)
Бараа материал	105,790.8	110,525.1	4,734.3
Үндсэн хөрөнгө	1,924,326.5	2,221,950.4	297,623.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,193,866.7</b>	<b>2,511,733.5</b>	<b>317,866.8</b>
Өр төлбөр	211,888.3	220,653.7	8,765.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,981,978.4	2,291,079.8	309,101.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,193,866.7</b>	<b>2,511,733.5</b>	<b>317,866.8</b>

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 179,258.0 мянган төгрөг болж 19,051.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 4,396,093.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 4,377,041.8 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 110,525.1 мянган төгрөг болж 4,734.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд урсгал санхүүжилтээс 220,010.4 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 215,276.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,221,950.4 мянган төгрөг болж, 297,623.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 404,594.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 1,073,850.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 220,653.7 мянган төгрөг болж 8,765.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Эрчим ХХК-д төлөх халаалтын төлбөрийн үлдэгдэл 216,279.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 4,457.1 мянган төгрөг, цахилгааны төлбөрийн үлдэгдэл 120.7 мянган төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,291,079.8 мянган төгрөг болж 309,101.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлан оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,832,679.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 361,330.8 мянга, нийт зарлагыг 3,194,010.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийг анх цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2,230,116.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 278,764.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 358,830.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,500.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 59,165.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 123,904.3 мянга, бусад урсгал шилжүүлгийг 140,729.4 мянган төгрөг, нийт 3,194,010.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тодотголоор 1,360,632.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсвийг 4,554,643.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 1,094,958.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 136,869.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 21,057.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 80,257.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 22,409.9 мянган төгрөгөөр өсөж, 4,554,643.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,029,762.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,906.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 366,330.8 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээс бүрдүүлэхээр төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,029,762.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 366,330.8 мянган төгрөг, нийт 4,396,093.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд оны эхний үлдэгдлээс 160,206.8 мянган төгрөг, тайлант хугацааны санхүүжилтээс 4,216,835.0 мянган төгрөг, нийт 4,377,041.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Нийт төсвийн гүйцэтгэл 4,377,041.8 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг 117,592.9 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөр төсвийг 14,225.8 мянган төгрөг, боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх төсвийг 32,882.4 мянган төгрөг, эрүү мэндийг дэмжих зардлыг 3,515.0 мянган төгрөгөөр хэмнэсэн буюу тодруулбал, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 94,866.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11,855.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 16,898.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 39,754.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71802 – ерөнхий боловсрол</b>	<b>4,554,643.00</b>	<b>4,377,041.90</b>	<b>177,601.1</b>	<b>96.1</b>
1.1	80111 - төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	366,330.8	366,330.8	-	100.0
1.2	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	8,068.1	8,068.1	-	100.0
1.3	80233 - хүүхэд хамгаалал	8,189.4	8,189.4	-	100.0
1.4	80312- Сургалт семинар	6,021.5	6,021.5	-	100.0
1.5	81605 - эрүүл мэндийг дэмжих	11,714.6	8,199.6	3,515.0	70.0
1.6	81801 – үдийн цай хөтөлбөр	163,220.3	148,994.5	14,225.8	91.3

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1.7	81816 - зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	60,495.2	60,495.2	-	100.0
1.8	81823 - боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	33,382.4	500.0	32,882.4	1.5
1.9	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	12,736.0	12,736.0	-	100.0
1.10	81834 - боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	3,704,151.8	3,586,558.9	117,592.9	96.8
1.11	81835 – сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	163,338.5	163,330.0	8.5	100.0
1.12	81848- Сурах бичгийн түрээс	1,906.4	-	1,906.4	-
1.13	81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	15,088.0	7,617.9	7,470.1	50.5

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 96.1 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Сургууль нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 131.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дугаар хамтарсан тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг баримтлан ажилласан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны төсвийн жилд худалдан авалтын төлөвлөгөө гараагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.

2024 оны төсвийн жилд тусгай зориулалтын материалд 2,223.4 мянган төгрөг, эм боох зардал 780.1 мянган төгрөг, Бичиг хэргийн материалын зардал 27,231.1 мянган төгрөг, аж ахуйн материал 15,120.6 мянган төгрөг, барилгын засварын материал 23,227.7 мянган төгрөг, хүнсний материал 148,579.4 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2,482.0 мянган төгрөгөөр тус тус худалдаж авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор цалингийн нэмэгдэл урамшуулал, үндсэн хөрөнгийн бүртгэл болон баримт баталгаажуулалт, Төрийн хэмнэлтийн хуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Лайт энд Дилайт Аудит” ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,017,348.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,260.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 31 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 171 мэдээллээс 167 мэдээллийг бүрэн байршуулж, байршуулах хугацаа нь болоогүй 4 мэдээлэл байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,930.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн нь 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	3,300.0	1	3,300.0	100.0
Албан шаардлага	1	3,630.5	1	3,630.5	100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>6,930.5</b>	<b>1</b>	<b>6,930.5</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар сургуулийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн.

Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа<sup>1</sup> илрээгүй болно.

Аудитаар нийт 6,310.6 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,853.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд: Тайлан жилийн эцэст НДШ-ийн өглөгийн үлдэгдлийг НДХэлтэстэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар санхүүгийн ажилтантай холбоотой зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов.

1. Сургуулийн захирлын 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн Б/36 дугаар тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл оногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад сургуулийн захирлын 2024 оны 6 дугаар сарын 18-ний өдрийн А/26 дугаар, 12 дугаар сарын 23-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар нягтлан бодогчид нийт 1,853.4 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", 123.9-д "Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр мэдэгдэнэ", ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 3 "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

### 5.2 Зөвлөмж

#### 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна", Засгийн газрын 2025 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолоор батлагдсан ""Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

## **2. Өглөгийн үлдэгдлийн баталгаажуулалттай холбоотой асуудал**

### 2.1. Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн жилийн эцсийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй байна.

### 2.2. Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийг тайлант хугацаа бүр тооцоо нийлж баталгаажуулж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс						/мянган төгрөгөөр/			
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн.	1	-	-	-	-	1	-	-	-	-	-
НДШ-ийн жилийн эцсийн өглөгийн үлдэгдлийг НДХэлтэстэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	4,457.2	-	-	-	1	4,457.2	-	-	-	-
<b>ДҮН</b>	<b>2</b>	<b>4,457.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>4,457.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс						/мянган төгрөгөөр/			
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлтэй байх хугацаанд нягтлан бодогчид улирлын үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	1,853.4	-	-	-	-	-	-	-	-	-
<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>1,853.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>